|                             | fg6                                                       | g6              | ef7             | f8              | f9              | e9                | k6              | m6              | n6              | p6              | r6              | s7              |
| Голны бүрээсний зузаан, мкм |                                                           |                 |                 |                 |                 |                   |                 |                 |                 |                 |                 |                 |
| 1-3                         | 3-6                                                       | 3-6             | 3-6             |                 |                 | 3-6               |                 |                 |                 |                 |                 |                 |
| 3-6                         |                                                           |                 | 6-9             |                 |                 |                   |                 |                 |                 |                 |                 |                 |
| 6-10                        |                                                           | 6-9             | 9-15            |                 |                 |                   |                 |                 |                 |                 |                 |                 |
| 10-18                       |                                                           |                 |                 |                 |                 |                   |                 |                 |                 |                 |                 |                 |
| 18-30                       |                                                           |                 |                 |                 |                 |                   |                 |                 |                 |                 |                 |                 |
| 30-50                       |                                                           |                 |                 |                 |                 |                   |                 |                 |                 |                 |                 |                 |

<sup>1</sup> Эд ангийн хэмжээний хүлцлийн талбарын хагасыг ашиглаж эд ангийг хийвэл завсартай суулт үүснэ. Эд ангийг хүлцлийн талбарын хязгаарын хазайлтаар гүйцэтгэх, түүнчлэн бүрээсний хамгийн зузаан хэмжээгээр бүрэх, мөн эд ангийн нь 10 мм хүртэл хэмжээтэй байх үед бага хэмжээний шахалттай суулт үүснэ. Энэ тохиолдолд эд анги нь бүх урт болон голчоороо шүргэлцэж байвал металл бүрээс ашиглахгүй. Хамгаалалтыг Хим.Фос.прм бүрээсийг ашиглаж гүйцэтгэнэ.

<sup>2</sup> Хүлцлийн муж fg6, ef7-г ГОСТ 25347 стандартын хүлцлийн талбарын нэмэлт цуваанаас авсан болно.

2. Зайтай суулттай, 50 мкм-с их хэмжээтэй голны бүрээсний зузааныг 9-15 мкм байхаар авна.

3. Завсартай, шилжилттэй, чангалалттай суултын нүхний бүрээсний зузаан бүх интервалд 3-6 мкм байна.

4. Эд ангид суултын эрээст болон гөлгөр гадаргуу хоёул байвал тухайн эд ангийн бүрээсний хамгийн бага зузааныг эрээст болон гөлгөр гадаргуугийн бүрээсний хамгийн бага зузаанаар авна.

5. 1-50 мм интервал дахь хүлцлийн муж fg6, ef7-н нэмэлт цувааны хязгаарын хазайлтын утгыг 2-р хүснэгтэд үзүүлэв.

6. 1-6 мм хэмжээтэй холхивчны суулгалтын хүлцлийн муж e7, 6-30 мм хэмжээтэй бол ef7 (хүснэгт-2), 30 мм-с их бол f7 байна. Энэ тохиолдолд бүрээсний зузаан 3-6 мкм байна.

## Б.2-р хүснэгт

| Хэмжээ, мм | Хүлцлийн талбарын хязгаарын хазайлт, мкм |            |
|------------|------------------------------------------|------------|
|            | fg6                                      | ef7        |
| 1-3        | -4<br>-10                                | -10<br>-20 |
| 3-6        | -6<br>-14                                | -14<br>-26 |

|       |            |            |
|-------|------------|------------|
| 6-10  | -8<br>-17  | -18<br>-33 |
| 10-18 | -11<br>-22 | -24<br>-42 |
| 18-30 | -13<br>-26 | -30<br>-51 |
| 30-50 | -17<br>-33 | -36<br>-61 |

7. Эд ангийн хэмжээг бүрээс хийхийн өмнөх шалгалт болон бүрээсний зузааны шалгалтаар баталгаажуулна.

8. Суулгасан эд ангиудын хамгийн тохиромжтой харьцах харьцааг хангах, тухайн эд ангиудыг хийж гүйцэтгэсэн квалитетээс хамаарах, бүрээс хийхийн өмнөх нүх болон голны хүлцлийн мужыг сонгох жишээ:

**Жишээ 1.** Бүрээс хийхийн өмнөх зайтай суултын хүлцлийн талбарын сонголт.

Өгөгдөл: Голч 20 мм, суулт  $\frac{H9}{h8}$ .

Гүйцэтгэл: 3-6 мкм зузаан бүрээстэй, 20 мм голчтой H9 нүх (3-р зүйлийг үз), 20 мм голчтой h8 (1-р хүснэгтийн дагуу 18-30 мм интервалд бүрээсний зузаан 6-9 мкм), голны оронд 20 мм голчтой f8 гол.

**Жишээ 2.** Бүрээс хийхийн өмнөх шилжилттэй суултын хүлцлийн талбарын сонголт.

Өгөгдөл: Голч 20 мм, суулт  $\frac{H7}{k6}$ .

Гүйцэтгэл: 3-6 мкм зузаан бүрээстэй, 20 мм голчтой H7 нүх (3-р зүйлийг үз), 20 мм голчтой (1-р хүснэгтийн дагуу 18-30 мм интервалд бүрээсний зузаан 6-9 мкм) k6 гол.

**Жишээ 3.** Бүрээс хийхийн өмнөх шахалттай суултын хүлцлийн талбарын сонголт.

Өгөгдөл: Голч 20 мм, суулт  $\frac{H7}{p6}$ .

Гүйцэтгэл: 3-6 мкм зузаан бүрээстэй, 20 мм голчтой H7 нүх (3-р зүйлийг үз), 20 мм голчтой (1-р хүснэгтийн дагуу 18-30 мм интервалд бүрээсний зузаан 6-9 мкм) p6 гол.

В хавсралт  
(Лавлах)

**Олон улсын стандартын болон тус стандартын дагуух бүрээсний ашиглалтын нөхцлийн бүлгийн тэмдэглэгээний тохирол**

| Бүрээсний ашиглалтын нөхцөлүүдийн бүлгүүдийн тэмдэглэгээ |                                           |
|----------------------------------------------------------|-------------------------------------------|
| Тус стандартын дагуу                                     | Бүрээсний олон улсын ISO стандартын дагуу |
| 1                                                        | 0*                                        |
|                                                          | 1                                         |
| 2                                                        | 2                                         |
| 3                                                        |                                           |
| 4                                                        |                                           |
| 5                                                        | 3                                         |
| 6                                                        |                                           |
| 7                                                        | 4                                         |
| 8                                                        |                                           |

\* Зэврэлтээс хамгаалахгүйгээр гоёл чимэглэлийн зориулалтаар хэрэглэнэ.

## Бүрээсүүдийн үндсэн шинж чанар ба металлын экологийн шинж чанарууд

### Г.1. Цайран бүрээс

1.1 Хар металлын хувьд цайран бүрээс нь анод тал байх бөгөөд 70°C хүртэлх температурт ганг цахилгаан-химийн аргаар зэврэлтээс хамгаалах ба түүнээс өндөр температурт механик хамгаалалт болдог.

Ийм бүрээс нь ганг хөнгөн цагаан болон хөнгөн цагааны хайлшаар хийсэн эд ангитай харьцах үед зэврэлтээс хамгаална. Мөн эрээст эд ангиудын эрэгдэх чанарыг нэмэгдүүлнэ.

Цайр нь гальванотехникт ашиглагддаг бусад металлуудтай харьцуулбал хүний биед хор багатай. Хүний бие организм цайрын хэрэгцээгээ хүнс болон ундны усаар дамжуулан авдаг. Цайрын давсны хортой хэмжээ нь хурц, үл эмчлэгдэх хордлогод хүргэдэг.

1.2 Зэврэлтэнд тэсвэрлэх чанарыг нэмэгдүүлэхийн тулд цайран бүрээсийг хромжуулах болон фосфатжуулдаг. Хромжуулах нь бүрээсний үзэмжийг сайжруулдаг. Хром хальсан бүрээс нь механик гэмтэлд өртөмхий хэврэг.

1.3 Хүний гар, багаж хэрэгсэл гэх мэтийн тогтмол механик нөлөөлөлд хромжуулсан цайран бүрээсийн үзэмж нь дорддог.

1.4 Хромжуулалт болон фосфатжуулалтгүй бүрээсийг цахилгаан дамжуулалтыг хангах, 100 °C –с дээш хэмд пластмассаар шахах зэрэгт ашигладаг.

1.5 Цахилгаан-химийн аргаар цайраар бүрэхэд устөрөгчийн улмаас гангийн налархай чанар алдагддаг. 1380 МПа (140 кгх/мм<sup>2</sup>) -с дээш урсалтын хязгаартай ганг цайраар бүрдэггүй.

1.6 Ийм бүрээс нь үндсэн металлтайгаа сайн барьцалддаг, механик үйлчлэлд тэсвэр багатай, 250°C –с их, -70°C-с бага температурт илүү хэврэг; бүрзгэр өнгөтэй бүрээс нь гулзайлт, мөн хоолойн амсрыг өргөтгөх зэрэгт тэсвэртэй.

1.7 Цахилгаан-химийн аргаар бүрсэн бүрээсийн бичил хатуулаг нь дунджаар 490-1180 МПа (50-120 кгх/мм<sup>2</sup>) байна. Хувийн цахилгаан эсэргүүцэл нь 18°C температурт  $5.75 \cdot 10^{-8}$  Ом·м байна.

### Г.2. Кадмий бүрээс

2.1 Кадмий бүрээс нь анод тал байх бөгөөд ганг агаар болон нуурын усанд цахилгаан-химийн аргаар, цэвэр усанд механикаар зэврэлтээс хамгаална.

Кадмийн бохирдол хүний хүнсний бүтээгдхүүний бусад бүх төрлийн металлын бохирдлуудаас илүү аюултайд тооцогддог. Хүний организм 6% орчим кадмийг хүнсээр дамжуулан авч тэр нь организмаас бараг гадагшилдаггүй. Хүний бие организм кадмийг тогтмол авах нь бөөр, ясыг хүндээр өвчлүүлж гэмтээдэг. Кадмийн тогтмол удаан хугацааны нөлөөлөл нь цус багадалт ба цусны даралт ихсэхэд хүргэдэг. Организм дахь кадмийн хорыг бусад металлуудаар бууруулдаг. Кобальт, селен, түүнчлэн цайр болон цайрын хелатууд кадмийн хорыг зөөлрүүлдэг.

2.2 Зэврэлтэд тэсвэрлэх чанарыг нэмэгдүүлэх үүднээс кадмий бүрээсийг хроматжуулах болон фосфатжуулдаг. Хроматжуулах нь бүтээгдхүүний үзэмжийг сайжруулдаг. Хроматын хуудас нь механик үйлчлэлд тэсвэргүй.

Зэврэх хурд нь үйлдвэрлэлийн орчинд цайрын бүрээснээс 1,5-2 дахин их байна.

2.3 Металлын цахилгаан дамжуулах чанарыг хадгалхын тулд 100°C дээш хэмд пластмассаар бүрэх үед хромжуулж, фосфатжуулдаггүй.

2.4 Хүхрийн нэгдлүүд бүхий шатахуунтай харьцдаг орчин, хуучрах үедээ органик бодисоос дэгдэмхий, идэмхий нэгдэл ялгаруулдаг агаар орчин (олиф, тосон лак хатах үед г.м.), үйлдвэрийн бүсэд ажиллах эд ангиудыг бүрэхийг зөвлөдөггүй.

2.5 Ганг цахилгаан-химийн аргаар кадмигаар бүрэх үед устөрөгчийн улмаас налархай чанараа алддаг. 1370 МПа (140 кгх/мм<sup>2</sup>) –с дээш бат бэхийн хязгаартай гангаар хийгдсэн эд ангийг тусгай технологиор кадмигаар бүрнэ.

2.6 Тус бүрээс нь үндсэн металлтай сайн барьцалддаг, үрэлтэд тэсвэрлэх чанар өндөртэй, элэгдэл тэсвэрлэх чанар муутай, цайраас илүү уян. Дарах, сунгах, мөн хоолойн амсрыг өргөтгөх, эрэгдэх зэрэгт тэсвэртэй.

Кадмийн исэл нь хортой. Кадмийгаар бүрсэн гадаргууд гагнуур хийж болохгүй.

2.7 Кадмий бүрээсийн бичил хатуулаг нь 340-490 МПа (35-50 кгх/мм<sup>2</sup>); 18°C хэмд хувийн цахилгаан эсэргүүцэл нь  $10,98 \cdot 10^{-8}$  Ом·м байна.

### **Г.3. Никель бүрээс**

3.1 Никель бүрээс нь ган, хөнгөн цагаан, цайрын хайлшын хувьд катод тал байна. Ийм бүрээсийг эд ангийг хамгаалах, үзэмжийг сайжруулах, гадаргуугийн бат бөх чанарыг нэмэгдүүлэх, элэгдэлд тэсвэрлэх болон цахилгаан дамжуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор ашигладаг.

Никель нь хүний биед хортой бодис биш. Үйлдвэрлэлийн хог хаягдлаар ус суваг бохирдсоноос үүдэн хүний бие организмд никель ихэсдэг.

3.2 Бүрээсний гадаргуугийн үзэмжийг сайжруулхын тулд никель суурь үе дээр 1 мкм зузаантай хром түрхдэг.

3.3 Зэврэлт тэсвэрлэх чанарыг нэмэгдүүлхийн тулд өөр өөр физик-химийн шинж чанартай хэд хэдэн үе никель бүрээс тавьдаг. 24 мкм зузаантай хоёр давхар бүрээсний (зэсийн суурь үегүй) хамгаалах шинж чанар нь гялалзсан бүрээсний хамгаалах шинж чанараас хоёр дахин, дүүргэгчтэй гурван үетэй бүрээснийхээс гурав дахин их байдаг.

3.4 18°C хэмд хувийн цахилгаан эсэргүүцэл нь  $7.23 \cdot 10^{-8}$  Ом·м байна. Гялалзсан гадаргын бичил хатуулаг чанар нь 4420-4900 МПа (450-500 кгх/мм<sup>2</sup>), хагас гялзсан гадаргуутай бүрээснийх 2940-3930 МПа (300-400 кгх/мм<sup>2</sup>) байна. Гялалзсан гадаргын ойлтын коэффициент нь 75% байна. Ажлын зөвшөөрөгдөх температур нь 650°C байна.

3.5 Ийм бүрээс нь алт, мөнгө, цагаан тугалганы хайлш, хар тугалга болон бусад металлаар бүрхэд хамгаалалтын үе болж зэс, цайр, төмөр болон бусад металлуудын нэвчилтийг зогсоодог.

3.6 Хар никель бүрээсийг эд ангийн тусгай оптик чанар үзэмжийг сайжруулах зорилгоор ашигладаг. Хар никель бүрээсний ойлтын коэффициент нь 20% хүртэл байна.

### **Г.4. Химийн никель бүрээс**

4.1 3-12% фосфорын агууламжтай химийн никель бүрээс нь цахилгаан-химийн аргаар хийсэн никель бүрээстэй харьцуулбал хамгаалах чадвар илүү сайн. Ийм гадарга нь хатуулаг чанар өндөртэй, элэгдэлд тэсвэртэй байдаг тул тосолгоогүй, үрэлт ихтэй орчинд ажилладаг эд ангиудад тохиромжтой. Мөн нам температурт гагнагдах чанарыг нэмэгдүүлнэ, зэврэлтээс хамгаална.

Ийм бүрээс илүү хэврэг тул химийн никель бүрээстэй хэсгийг нугалах, хоолойн амсрыг өргөтгөхийг зөвлөдөггүй.

4.2 Бүрээсийг ихэвчлэн нарийн төвөгтэй хэлбэр дүрстэй хэсгүүдэд ашиглахыг зөвлөдөг.

4.3 Ийм бүрээсэнд 400°C хэмд дулааны боловсруулалт хийсний дараа бат бөх чанар нь сайжирдаг.

4.4 Дулааны боловсруулалт хийсний дараа бүрээсийн бичил хатуулаг нь 6400-11800 МПа (650-1200 кгх/мм<sup>2</sup>), 18°C хэмд хувийн цахилгаан эсэргүүцэл нь  $6.8 \cdot 10^{-7}$  Ом·м байна.

### Г.5. Хром бүрээс

5.1 Хром бүрээс нь ган, хөнгөн цагаан болон цайрын хайлштай харьцангуй катод тал болох ба зэврэлтээс хамгаалж өнгө үзэмжийг нэмэгдүүлнэ.

Хром нь хүний бие организмд хортой металлын ангилалд багтах бөгөөд хордуулалтын зэрэг нь түүний исэлдэлтийн зэргээс хамаарна. Зургаан валенттай хромын нэгдэл нь гурван валенттай хромын нэгдлээс илүү хортой. Хаягдал бохир усанд агуулагдах зургаан валенттай хромын давсны өндөр агууламж нь усан сангуудын микро орчинд хортой нөлөө үзүүлдэг.

5.2 Хамгаалах, гоёл чимэглэлийн бүрээсийг никелийн дэвсгэр үен дээр 1.0 мкм хүртэл зузаантай нимгэн толин түрхэц байдлаар хийнэ. 0.5 мкм хүртэл зузаан бүрээс сүвэрхэг байх ба бүрээсийн зузааныг нэмэх үед торлог ан цав үүсдэг.

5.3 Цахилгаан химийн хромон бүрээс нь хатуу, сүвэрхэг, сүүн өнгөтэй байж болно.

5.4 Хатуу хромын бүрээс нь элэгдэл, халуунд тэсвэртэй, үрэлтийн коэффициент бага, уян налархай чанар муутай байдаг.

Бүрээс нь үрэлтэд сайн ажилладаг (хатуу суурь үе дээр хэрэглэх үед), жигд тархсан ачааллыг сайн тэсвэрлэдэг бөгөөд төвлөрсөн цохилтын ачааллын нөлөөнд амархан эвдэрдэг.

5.5 Сүүн өнгөтэй хром бүрээс нь хатуулаг багатай, элдэгдэлд тэсвэргүй, бага зэрэг сүвэрхэг. Ийм бүрээс нь зэврэлтээс хамгаалж, гоёл чимэглэлийн төрхийг хадгална.

5.6 Сүүн бүрээс гаргаж авах үеийн гангийн устөрөгчийн процесс нь хатуу бүрээс гаргаж авах үеийнхээс илүү хүчтэй явагдана.

5.7 Зэврэлтээс хамгаалах, гоёл чимэглэлийн өнгөлгөө, элэгдэлд тэсвэртэй байх шаардлагатай эд ангиудын хувьд сүүн болон хатуу хромоос бүрдсэн хосолсон бүрээсийг ашиглахыг зөвлөдөг.

5.8 Сүвэрхэг бүрээс нь эд ангиуд элэгдэлд тэсвэрлэх чанарыг нэмэгдүүлдэг. Ийм бүрээс нь салаалсан ан цавын сүлжээгээр тодорхойлогддог (нүхнүүд нэмэлт анодын нөлөөгөөр өргөсдөг).

5.9 Хар хромон бүрээсийг гэрэл шингээгч гадаргууг гаргаж авах зорилгоор ашигладаг. Ийм бүрээс нь үрэлтэд тэсвэр муутай. Хар хром бүрээсийн ойлтын коэффициент 3-4% байх ба вакуумд орчинд тогтвортой байна.

5.10 Нарийн төвөгтэй хэлбэр дүрстэй эд анги дээр хромон бүрээс хийх нь хромын электролитийн сарниулах чадвар бага байдгийн улмаас хүндрэлтэй байдаг.

5.11 Зэврэлт тэсвэрлэх чанарыг нэмэгдүүлэхийн тулд хромоор бүрсэн эд ангиудад нэмэлт боловсруулалт (гидрофобизаци, нэвчилт гэх мэт) хийж болно.

Нуурын усанд шууд өртөх нөхцөлд ажиллах, хромоор бүрсэн эд ангиудын нэмэлт хамгаалалтын тосолгоог үе үе сэргээж байхыг зөвлөдөг.

5.12 Хатуу хромын бүрээсийн бичил хатуулаг - 7350-10780 МПа (750-1100 кгх/мм<sup>2</sup>), харин хар хром бүрээсийнх - 2940-3430 МПа (300-350 кгх/мм<sup>2</sup>) байна.

### **Г.6. Зэс бүрээс**

6.1 Зэс бүрээс нь ган, хөнгөн цагаан, магни, цайрын хайлш зэрэгтэй харьцангуй катод болдог. Ийм бүрээсийг гадаргуугийн сүвэрхэг чанарыг багасгах, бусад бүрээстэй барьцалдах чанарыг сайжруулах үүднээс технологийн суурь үе болгон ашигладаг. Зэврэлтэнд тэсвэрлэх чанар муутай тул бүрээсийг дангаар нь ашиглахыг зөвлөдөггүй.

Зэс нь усны амьтдад ихээхэн хортой. 0.001 мг/см<sup>3</sup>-ийн агууламжтай зэсийн давс нь усны олон организмын хөгжлийг сааруулдаг ба 0,004 мг/см<sup>3</sup>-ийн агууламжтай үед тэдгээрт хортой нөлөө үзүүлдэг. Зэсийн давсны хортой тун нь хүний цочмог боловч эмчлэх боломжтой хордлогод хүргэдэг.

6.2 Зэс бүрээс нь цахилгаан, дулаан дамжуулалт өндөр, уян налархай чанартай, суналт, хоолойн амсрын өргөсөлт хийхэд тэсвэртэй, өнгөлгөө сайн авдаг, эрэгдэх чанар сайтай.

6.3 Бүрээсийн ажлын зөвшөөрөгдөх температур нь 300°C, бичил хатуулаг - 590-1470 МПа (60-150 кгх/мм<sup>2</sup>); 18°C хэмийн хувийн цахилгаан эсэргүүцэл -  $1.68 \cdot 10^{-8}$  Ом·м байна.

### **Г.7. Зэс цагаан тугалганы хайлшин бүрээс**

7.1 Цагаан тугалганы агууламж өндөртэй М-О(60) хайлшаар бүрэх нь гантай харьцангуйгаар катод байх тул, цахилгаан гүйдэл дамжуулах деталиудтай харьцах эд ангиудын элдэгдэлд тэсвэрлэх чанарыг нэмэгдүүлэх, халуунаар гагнах боломжыг сайжруулхад ашиглана. Ийм бүрээсийг хамгаалалтын болон гоёл чимэглэлийн зориулалтаар ашиглаж болно.

7.2 Ийм бүрээс нь шүлт, сул органик хүчил, хүхрийн нэгдлүүдэд тэсвэртэй.

7.3 Ийм бүрээсийн ойлтын коэффициент 60-65%, элэгдэлд тэсвэртэй чанар нь мөнгөн бүрээсийнхээс 4 дахин их, хатуулаг нь зэс бүрээснийхээс 5-6 дахин их.

7.4 Канифолийн жац ашиглахад нам температурт сайн гагнагдана.

7.5 Ийм бүрээсэнд хялгасан кристалл үүсэхгүй, нам температурт нунтаг хэлбэрт шилжихгүй.

7.6 Бүрээсний бичил хатуулаг - 5390-6370 МПа (550-650 кгх/мм<sup>2</sup>).

### **Г.8. Цагаан тугалган бүрээс**

8.1 Цагаан тугалган бүрээс нь агаар орчины нөхцөлд гантай харьцангуй катод, олон төрлийн органик орчинд, мөн 50%-с дээш зэс агуулсан зэс, түүний хайлштай орчинд анод болдог. Ийм бүрээсийг халуунаар гагнах боломжыг хангах зорилгоор ашигладаг.

Хүний биед хоол хүнс, ундны усаар орсон цагаан тугалга нь биеэс хурдан гадагшилдаг. Бие махбодид цагаан тугалга нь бөөр, элэг, яс, зөөлөн эдэд бага хэмжээгээр хуримтлагддаг. Араг ясанд хамгийн их хэмжээгээр хадгалагддаг.

8.2 Цагаан тугалга бүрээс нь хүхрийн нэгдлүүдэд тэсвэртэй бөгөөд бүх төрлийн хуванцар, резинтэй харьцдаг хэсгүүдэд хэрэглэхийг зөвлөдөг.

8.3 Цагаан тугалган бүрээс нь суурь металлтай сайн барьцалддаг, уян, нугалах сунгах, хоолойн амсрыг өргөсгөх зэрэгт хялбар, хэв гаргах, даралт өгөхөд тэсвэртэй. Эрэгдэхэд эрээс дээрхи бүрээс нь сайн хадгалагддаг.

Шинэ цагаан тугалга нь халуун гагнуур хийхэд сайн гагнагддаг. Гялалзсан бүрээс нь бүрзгэр гадаргуутай бүрээсээсээ гагнагдах чадвараа илүү удаан хадгалдаг.



8.4 Бүрзгэр гадаргуутай цагаан тугалга нь мэдэгдэхүйц сүвэрхэг чанартай байдаг. Бага зузаантай (6 мкм хүртэл) бүрээс дээрхи нүх сүвийг бүрээсийг нь хайлуулах эсвэл гялалзуулах замаар бууруулж болно.

8.5 Хадгалалтын явцад бүрээсийн гадаргууд гүйдэл дамжуулах шинж чанартай үсэрхэг талстууд ("зүү") үүсдэг.

8.6 Цагаан тугалган бүрээсийг +13°C хэмээс доош температурт ашиглах үед нягт цагаан тугалга нь нунтаг саарал тугалга болж хувирах ба үүний улмаас бүрээс эвдэрч болно. (үүнийг "цагаан тугалганы тахал" гэдэг).

8.7 Бүрээсийн бичил хатуулаг 118-198 МПа (12-20 кгх/мм<sup>2</sup>), +18°C хэмийн температурт хувийн цахилгаан эсэргүүцэл нь  $11.5 \cdot 10^{-8}$  Ом·м, бүрээсийн ажлын зөвшөөрөгдөх температур нь 200°C байна.

### **Г.9. Цагаан тугалга - никелийн хайлшин бүрээс**

9.1 O-N(65) хайлшин бүрээс нь гантай харьцуулахад катод тал болох ба халуун гагнуураар холбогдох эд ангиудыг хамгаалах зорилгоор ашиглана. Мөн гадаргуугийн бат бөх чанар ба элэгдэлд тэсвэртэй чанарыг хангана.

9.2 Ийм бүрээс нь зэврэлтэнд тэсвэртэй. Мөн өндөр чийгшилтэй, хүхрийн нэгдлүүд агуулсан орчинд тэсвэртэй.

9.3 Ийм бүрээс өнгөлгөө сайн авдаг, хуванцарт шигтгэхэд тэсвэртэй, ихээхэн хэврэг тул гадаргууг сунгах болон цохилтын ачаалал хүлээж авах хэсгүүдэд хэрэглэхийг зөвлөдөггүй.

9.4 Бичил хатуулаг нь 4900-5880 МПа (500-600 кгх/мм<sup>2</sup>) байна.

Ажлын зөвшөөрөгдөх температур 300-350°C.

### **Г.10. Цагаан тугалга - висмутын хайлшин бүрээс**

10.1 Агаар орчинд O-Ви (99.8) хайлшин бүрээс нь гантай харьцангуй катод болох ба, зэс болон 50%-иас дээш агууламжтай зэсийн хайлшийн хувьд анод болно. Халуун гагнуураар гагнагдах эд ангиудыг хамгаалахад ашиглана.

10.2 Зэврэлтэнд тэсвэртэй чанар, үсэрхэг зүү үүсэх байдал нь цагаан тугалга бүрээстэй ижил байна.

10.3 Ийм бүрээсээр бүрсэн эд ангиудын ирмэгийг өргөсгөхөд тэсвэртэй, хэвэнд хялбар орно, эрэгдэх үед эрээс дээрхи бүрээс нь сайн хадгалагдана.

### **Г.11. Цагаан тугалга – хар тугалганы хайлшин бүрээс**

11.1 Гадна агаарын орчинд O-C(60) хайлшин бүрээс нь гантай харьцангуй катод, зэс ба түүний хайлштай харьцангуй анод болдог.

Ийм бүрээсийг бага температурын гагнуураар гагнаж болно.

Хар тугалга нь хүний эрхтэн, цусны эмгэгийг үүсгэдэг микро-элемент юм. Амьдралын туршид хар тугалга нь ясанд хуримтлагддаг. Ус, хоол тэжээлээр биед орох хар тугалгыг шингээх шингээлт хүүхдэд илүү ихээр ажиглагддаг.

11.2 Өндөр температур болон чийгшил ихтэй нөхцөлд зэврэлтэнд тэсвэртэй байдал нь цагаан тугалган бүрээснээс сул байдаг.

11.3 Ийм бүрээс нь уян налархай, цахилгааны эсэргүүцэл багатай, идэвхжүүлээгүй канифоль жац ашиглан халуун гагнуураар гагнаж болно.

11.4 Хайлуулсан байдалд ашиглалтын үзүүлэлт нь хамгийн сайн.

11.5 Хайлмал бүрээст зүү шиг гадаргуу үүсдэггүй. Цайр агуулсан хайлш дээр цайрын суурь үенд зүү шиг гадаргуу үүсэх болон цайр бүрээс рүү нэвчихээс сэргийлж никель суурь давхарга дээр хэрэглэнэ.

11.6 Полимер материал руу шахсны дараа идэвхжүүлээгүй канифоль жацыг ашиглаж бүрээсийн халуунаар гагнагдах чанарыг сэргээдэг.

### **Г.12. Алтан бүрээс**

12.1 Алтан бүрээс нь бүрэх металлтай харьцангуй катод болох бөгөөд механик хамгаалалт болдог. Деталийн гадаргуугийн цахилгаан дамжуулах чанарыг нэмэгдүүлэх, мөн цахилгаан эсэргүүцлийг тогтвортой болон бага хэмжээтэй байлгах зорилгоор ашиглаж болно.

12.2 Ийм бүрээс нь цахилгаан, дулаан дамжуулах өндөр шинж чанартай байдаг. Ердийн нөхцөлд, мөн өндөр чийгшилтэй гадна агаарын нөхцөл болон хүхэр агуулсан орчинд химийн бодисын үйлчлэлд тэсвэртэй байдаг.

12.3 Ашиглалтын 4-8-р нөхцөлийн хувьд хэлхээний хооронд ихэвчлэн бага зай завсартай, алтаар болон алтны хайлшаар бүрсэн бүлэг контактуудыг битүү орчинд эсвэл тоос, ус орохоос хамгаалсан саванд байрлуулах шаардлагатай.

12.4 Контактлах төхөөрөмжид ашигладаг цианист электролит бүрээс нь ажиллагааны явцад үрэлтийн гадаргуугийн наалдацыг ихэсгэх талтай байдаг. Хүчиллэг электролит бүрээст ийм согог илрэхгүй.

12.5 Алтан бүрээсийг гуулин гадаргууд хийхдээ сууринд нь никель дэвсгэр үе тавих нь зүйтэй. Никель дэвсгэр үе нь алтан бүрээсийн гадаргууд цайр үндсэн металлаас нэвчиж гарч ирэхээс хамгаална.

12.6 Цагаан тугалга-хар тугалгаар халуунаар гагнах үед алтан бүрээс нь металл хоорондын хэврэг холбоос үүсгэнэ. Энэ нь халуунаар гагнасан холбоосны механик бат бэхийг бууруулна.

12.7 Бүрээсийн бичил хатуулаг нь 392-980 МПа (40-100 кгх/мм<sup>2</sup>), 18°C температурт хувийн цахилгаан эсэргүүцэл нь  $2.2 \cdot 10^{-8}$  Ом·м, дотоод хүчдэл нь 59-147 МПа (6-15 кгх/мм<sup>2</sup>) байна.

### **Г.13. Алт-никелийн хайлшин бүрээс**

13.1 Зл-Н (99.5-99.9), Зл-Н (98.5-99.5), Зл-Н (93.0-95.0) хайлшин бүрээс нь үндсэн металлтай харьцангуй катод болох бөгөөд механик хамгаалалт болно. Алт-никелийн хайлшийн зэврэлтэнд тэсвэртэй байдал болон зориулалт нь алтан бүрээсийнхтэй адил байна.

13.2 Ийм бүрээс нь цахилгаан ба дулаан дамжуулалт сайтай, хатуулаг өндөртэй, элэгдэлд тэсвэртэй, гагнагдах чанар сул, дотоод хүчдэл багатай. Янз бүрийн идэмхий орчинд химийн бодисын үйлчлэлийг тэсвэрлэх чанараа тодорхой хугацаанд нь тогтвортой хадгалдаг.

13.3 Никел дэвсгэр үе нь бүрээсийг үрэлтэд тэсвэртэй болох нөхцлийг хангадаг. 350°C хүртлэх температурт үндсэн металлын нэвчилтээс сэргийлж, гадаргуугийн үрэлтийн эсэргүүцлийг тогтвортой байлгахад тустай.

13.4 Цагаан тугалга-хар тугалгаар халуунаар гагнах үед тус бүрээс нь металл хоорондын хэврэг холбоос үүсгэнэ. Энэ нь халуунаар гагнасан холбоосны механик бат бэхийг бууруулна.

### **Г.14. Мөнгөн бүрээс**

14.1 Мөнгөн бүрээс нь үндсэн металлын хувьд катод болно. Гадаргуугийн цахилгаан дамжуулах чанарыг нэмэгдүүлэх, үрэлтийг багасгах зорилгоор ашиглах нь зүйтэй.

14.2 Ийм бүрээс нь цахилгаан, дулаан дамжуулалах чанар сайтай, уян налархай, гэрэл ойлгох чанар сайтай, хатуулаг чанар багатай, механик элэгдэлд тэсвэртэй, мөн гагнахад хялбар байдаг.

Нугалах, гулзайлгах, эд ангиудын амсрыг өргөтгөх зэрэгт тэсвэртэй боловч полимер материалд шигтгэхэд тэсвэр багатай. Ийм бүрээс нь потенциалын ялгаварын нөлөөгөөр гадаргууд тархах хандлагатай. Бүрээс хийх электролитийн уусмал дахь ялалзуулагч нь бүрээсийн цахилгаан дамжуулах чанарт сөргөөр нөлөөлдөг.

14.3 Мөнгө нь алтаар дамжин нэвчиж гадаргууд цахилгаан үл дамжуулах хальс үүсгэдэг тул алтан бүрээсний доорх суурь үе болгож ашигладаггүй\*.

\*Мөнгөн суурь үетэй алтан бүрээстэй деталь болон түүнтэй харьцах деталь хоорондын цахилгааны шилжилтийн эсэргүүцэл нь мөнгө алтан бүрээсээр нэвчиж гарах явц зогсох хүртэл тогтворгүй байна.

14.4 Хлор, аммиак, хүхэр, фенол агуулсан нэгдлүүдийн нөлөөгөөр мөнгө агуулсан бүрээсний гадаргуу дээр хальс үүсдэг бөгөөд энэ нь бүрээсийн шилжилтийн эсэргүүцлийг ихэсгэж халуун гагнуураар гагнахад хүндрэлтэй болгодог.

14.5 Ийм бүрээсийн бичил хатуулаг нь 883-1370 МПа (90-140 кгх/мм<sup>2</sup>) бөгөөд энэ нь хугацааны явцад 558 МПа (60 кгх/мм<sup>2</sup>) хүртэл буурч болно, 18°C-ийн температурт хувийн цахилгаан эсэргүүцэл нь  $1.6 \cdot 10^{-8}$  Ом·м байна.

#### **Г.15. Палладий бүрээс**

15.1 Палладий бүрээс нь үндсэн металлын хувьд катод болох ба, агаар орчинд болон хүхрийн нэгдлүүдийн үйлчлэлд тэсвэртэй.

15.2 Ийм бүрээсийг харьцах гадаргуунуудын шилжилтийн эсэргүүцлийг бууруулах, тэдгээрийн гадаргуугийн бат бэх чанар, элэгдэлд тэсвэрлэлтийг нэмэгдүүлэх, цахилгаан эсэргүүцлийг тогтвортой хэмжээнд хадгалах шаардлагатай үед ашиглана.

15.3 Ийм бүрээс нь элэгдэлд тэсвэртэй, цахилгаан дамжуулалт сайн, хугацааны явцад контактын тогтвортой цахилгаан эсэргүүцэлтэй, ойлтын итгэлцүүр 60-70%. Цахилгаан дамжуулах чанар нь мөнгөн бүрээстэй харьцуулахад бараг долоо дахин бага боловч 300°C хүртэл температурт хугацааны туршид тогтвортой байдаг.

15.4 Энэхүү бүрээсийг органик материал, резинтэй харьцах гадаргууд, түүнчлэн эдгээр материалыг агуулсан битүү орчинд хэрэглэхийг зөвлөдөггүй. Уг бүрээсийг устөрөгчийн орчинд ашиглахыг хориглоно.

15.5 9 мкм-с зузаан бүрээсэнд бичил ан цав үүсдэг бөгөөд энэ нь тус бүрээсийн үндсэн зориулалтын болон хамгаалалах шинж чанарыг бууруулдаг.

15.6 Бүрээсийн бичил хатуулаг - 1960-2450 МПа (200-250 кгх/мм<sup>2</sup>); 18°C температурт хувийн цахилгаан эсэргүүцэл -  $10.8 \cdot 10^{-8}$  Ом·м, дотоод хүчдэл нь 686 МПа (70 кгх/мм<sup>2</sup>) хүрдэг.

#### **Г.16. Родий бүрээс**

16.1 Родий бүрээс нь үндсэн металлын хувьд катод болдог.

16.2 Ийм бүрээсийг тоног төхөөрөмжийн контактлах эд ангиудын цахилгаан шинж чанаруудыг тогтвортой хэмжээнд байлгах, гадаргуугийн ойлгох чадварыг нэмэгдүүлэхэд ашиглахыг зөвлөнө.

16.3 Ийм бүрээстэй гадаргуу нь элэгдэлд тэсвэртэй, цахилгаан дамжуулалт, гадаргуугийн ойлгох чанар өндөртэй байдаг. Ойлтын итгэлцүүр нь 76-81%.

Ийм гадаргууг ширээх боломжгүй, ихэнх зэврэлт үүсгэх орчинд тэсвэртэй, түүний дотор устөрөгчийн хүхэрт устөрөгчид 500°C хүртэл хэмд исэлддэггүй.

16.4 1.0 мкм зузаантай бүрээс нь бараг нүх сүвгүй, 3 мкм-с их зузаантай бүрээсэнд бичил ан цав үүсэх магадлалтай.

16.5 Ийм бүрээсийн бичил хатуулаг - 3920-7840 МПа (400-800 кгх/мм<sup>2</sup>); 18°C температурт хувийн цахилгаан эсэргүүцэл  $4.5 \cdot 10^{-8}$  Ом·м, дотоод хүчдэл нь 1670 МПа (170 кгх/мм<sup>2</sup>) хүрдэг.

### **Г.17. Анод-ислийн бүрээс**

17.1 Хөнгөн цагаан ба хөнгөн цагааны хайлшин дээр бүрэх

17.1.1 Аноджуулах үед эдлэхүүний хэмжээ нь ойроцоогоор бүрээсний зузааны хагастай тэнцэх хэмжээгээр нэмэгддэг.

17.1.2 Анод-ислийн бүрээсний чанар нь эдлэхүүний гадаргуугийн боловсруулалт сайжрах тусам нэмэгддэг.

17.1.3 Зэврэлтээс хамгаалхад ашигладаг анод-ислийн бүрээсийг ашиглалтын зориулалтаас нь хамааруулан калийн болон натрийн бихромат, эсвэл усан уусмалд дүрэх замаар хийдэг. Ийм бүрээс нь будаг, цавуу, чигжээс гэх мэтэд сайн суурь болдог. Эдлэхүүний үзэмжийг сайжруулах зорилгоор анод-оксид бүрээсийг тавихын өмнө янз бүрийн будгийн уусмалаар эдлэхүүнийг адсорбцийн аргаар, эсвэл металлын давсны уусмалд цахилгаан-химийн аргаар буддаг.

17.1.4 Хөнгөн цагааны хайлшаар аноджуулсан эд ангиудыг толигор гадаргатай болгохын тулд гадаргууг урьдчилан өнгөлхийг зөвлөдөг. Аноджуулсан хөнгөн цагаан ба түүний хайлшийн гадаргуугийн ойлгох чадвар дараах дарааллаар буурдаг: А99, А97, А7, А6, АД1, АМг1, АМг3, АД31, АД33.

17.1.5 20-100 мкм зузаантай анод-оксидын хатуу бүрээс нь элэгдэлд тэсвэртэй (ялангуяа тосолгооны материал ашиглах үед), мөн дулаан болон цахилгаан тусгаарлах шинж чанартай.

Анод-ислийн хатуу бүрээстэй эд ангиудыг механик боловсруулалтад оруулах боломжтой байдаг.

17.1.6 Анод-ислийн бүрээс нь сүвэрхэг бүтэцтэй, цахилгаан дамжуулахгүй, хэврэг, 100°C-с дээш хэмийн температурт халаах, эсвэл хэв гажилтанд оруулахад ан цав үүснэ.

17.1.7 Хүхрийн хүчлээр аноджуулах үед гадаргуугийн барзгаршил хоёр ангиллаар нэмэгддэг. Хромын хүчлээр аноджуулах нь гадаргуугийн барзгар байдалд багахан хэмжээгээр нөлөөлдөг.

Анод-ислийн бүрээсийг хийхдээ үндсэн металлын механик шинж чанарт үзүүлэх нөлөөг харгалзан үзэх шаардлагатай. Зузааныг нь ихэсгэх нь анод-оксидын бүрээсийн нөлөөллийг нэмэгдүүлэх ба хайлшны бүтцээс мөн хамаарна.

17.1.8 Хромын хүчилд аноджуулалтыг ихэвчлэн 5% -иас ихгүй зэс агуулсан хөнгөн цагаан хайлшаар хийсэн эд ангиудыг зэврэлтээс хамгаалахад ашигладаг бөгөөд голчлон 5-6 нарийвчлалтай (нарийвчлалын 1-2-р анги) эдлэхүүнд ашигладаг.

17.1.9 Ан.Окс.эиз бүрээсийг хөнгөн цагаан, хөнгөн цагааны хайлшаар хийсэн эд ангиудын гадаргууд цахилгаан тусгаарлах зорилгоор хэрэглэнэ.

17.1.10 Цахилгаан тусгаарлах зориулалтаар аноджуулах бол хурган чихний хүчлийн электролитын уусмал ашиглахыг зөвлөдөг.

Зохих будаг, лагыг шингээх эсвэл түрхсэний дараа бүрээсийн цахилгаан тусгаарлах чанар тогтвортой болдог. Шингээсэн бол бүрээсийн зузаан нь 3-7 мкм-р нэмэгдэх ба лак будган бүрээсийг түрхсэн тохиолдолд бүрээс нь 80 мкм хүртэл зузаантай болдог.

Бүрээсийн зузааныг нэмэгдүүлэх, сүвэрхэг байдлыг бууруулах, мөн түүнчлэн үндсэн гадаргуугийн чанарыг сайжруулахын хэрээр бүрээсийн цооролт тэсвэрлэх чанар нь нэмэгдэнэ.

Зураас, хонхорхой, хурц ирмэг гарах нь бүрээсийн цахилгаан тусгаарлах чанарыг бууруулдаг.

Бүрээсэнд цахилгаан тусгаарлагч лак шингээсний дараа цооролт тэсвэрлэх чанар нь бүрээсийн зузаанаас голчлон хамаардаг бөгөөд хөнгөн цагааны хайлшийн найрлага, аноджуулах процессын технологоос бага зэрэг хамаардаг.

17.1.11 Ан.Окс.эмт бүрээсийг хэв гажуулсан, бага чанаржуулсан хөнгөн цагааны хайлшаар хийсэн эдлэхүүнд үзэмжийг нь сайжруулах зорилгоор ашиглахыг зөвлөдөг.

17.1.12 5%-с дээш хувийн зэс агуулсан хайлшаар хийсэн эдлэхүүнүүдэд Ан.Окс.хром болон Ан.Окс.тв бүрээс хэрэглэхийг зөвлөдөггүй.

17.1.13 3%-с дээш хувийн зэс агуулсан хайлшаар хийсэн эдлэхүүнүүдэд Ан.Окс.эмт болон Ан.Окс.эиз бүрээс хэрэглэхийг зөвлөдөггүй.

17.1.14 Анод-ислийн бүрээс нь үндсэн металлтай сайн барьцалддаг, мөн үндсэн металлынхаас бага дулаан дамжуулах шинж чанартай, механик элэгдэлд тэсвэртэй. Д1, Д16, В95, АК6, АК8 маркийн хайлш дээрх бичил хатуулаг нь 1960-2450 МПа (200-250 кгх/мм<sup>2</sup>), А5, А7, А99, АД1, АМг2, АМг2с, АМг3, АМг5, АМг6, АМц, АВ маркийн хайлш дээр 2940-4900 МПа (300-500 кгх/мм<sup>2</sup>), эматаль бүрээсийн бичил хатуулаг нь 4900 МПа (500кгх/мм<sup>2</sup>), бүрээсний хувийн цахилгаан эсэргүүцэл нь  $10^7$ - $10^{12}$  ом·м байна.

17.2 Магнийн хайлшин дээр бүрэх

17.2.1 Магнийн хайлшаар хийсэн эд эдлэхүүнүүдийг хамгаалахын тулд органик бус бүрээсийг лак будган бүрээстэй хослуулан хэрэглэхийг зөвлөдөг.

17.2.2 Нэмэлт будаггүй анод-оксидын бүрээсийг идэмхий бус эрдсийн тосонд ажилладаг эдлэхүүнүүдийг хамгаалах, мөн ажилбар хоорондын хадгалалтын зориулалтаар ашиглана.

Эдлэхүүний эрээстэй гадаргуу дээр, мөн эдлэхүүнийг нягт суулгах үед суулгалтын гадаргуу дээр хэрэглэхгүй. Эдгээр тохиолдолуудад металл бүрээс дээр нэмэлт тосолгоо, хөрсжүүлэгч зэргийг хийж өгдөг.

17.2.3 Эдлэхүүний дотоод хөндийн хэсгийг хамгаалах болон багаж хэрэгсэлд лак шингээсэн анод-оксидын бүрээсийг ашиглахыг зөвшөөрнө.

17.2.4 Шингэн диэлектрикт ажилладаг эд ангиудыг зэврэлтээс хамгаалахын тулд анод-оксидын бүрээсийг нэвчүүлэлтгүйгээр, мөн будган бүрээсгүйгээр ашиглана.

17.2.5 Аноцвет бүрээс нь нэвчүүлэгч лакны барьцалдалтыг сайжруулах бөгөөд лак нэвчүүлсэний дараа өнгөлгөө сайн авдаг. Элэгдэлд өндөр тэсвэртэй, нэвтлэх хүчдэл 200 В-оос багагүй, мөн хэврэг, хурц ирмэг нь амархан эмтэрнэ, металлын цуцалтын бат бэхийг бууруулна.

Бүрээсний гадаргуугийн нягт нь 0.03-0.04 кг/м<sup>2</sup>, нэвчилт хийсний дараа - 0.035-0.05 кг/м<sup>2</sup> байна. Бүрээсний бичил хатуулаг - 1670-1960 МПа (170-200 кгх/мм<sup>2</sup>).

17.2.6 Аносвет бүрээсийг 6, 7, 8 хүлцэлийн багцийн (нарийвчлалын 2 ба 2а анги) суултын гадаргуутай эдлэхүүнүүдэд ашигладаг.

Бусад төрлийн хайлшаар хийсэн эдлэхүүнтэй харьцахаас тусгаарласан тохиолдолд Ан.Окс бүрээсийг угсралтын нэгж элементүүдэд хэрэглэж болно.

Бүрээсийн ажлын температур 400°C хүртэл байна.

17.2.7 Янз бүрийн хайлшаар хийсэн эдлэхүүнтэй харьцахаас тусгаарласан тохиолдолд Аноцвет бүрээсийг угсралтын нэгж элементүүдэд хэрэглэж болно.

5 мм-с бага голчтой урт суваг бүхий эд ангиудыг аноджуулахыг хориглоно.

Бүрээсийн ажлын температур 400°C хүртэл байна. Бүрээсийн зузаан 5-40 мкм. Бүрээсийн өнгө нь хэрэглэсэн электролитийн уусмалаас хамааран цагаан, ногоон эсвэл хар-саарал байж болно.

17.3 Титан болон титаны хайлшин дээр бүрэх

17.3.1 Анод-оксидын бүрээсийг будаг, лакны барьцалдалтыг нэмэгдүүлэх, эрээстэй деталийн эрэгдэх боломжийг хангах, гоёл чимэглэлийн өнгөлгөө хийхэд ашиглана.

Анод-оксидын бүрээс нь үндсэн металлтай сайн барьцалддаг, тасралтанд ажиллах үед наамал холбоосны бат бэх нь 29.4 МПа (300 кгх/см<sup>2</sup>)-с багагүй, шилжисхийлтэнд 12.8 МПа (130 кгх/см<sup>2</sup>)-с багагүй байна.

Цахилгаан тусгаарлах шинж чанартай, лак будган бүрээсгүй үед нэвтрэх хүчдэл 10-50 В, бүрээсийн гадаргуугийн нягт 0.002-0.004 кг/м<sup>2</sup>, элэгдэлд тэсвэртэй, үрэлтэд ажиллах үед металл наалдахаас сэргийлдэг.

Аноцвет бүрээс нь наамал холбоосны тасралтын болон шилжисхийлтийн бат бэх чанарыг хангана. Тасралтын бат бэх нь 11.8 МПа (120 кгх/см<sup>2</sup>)-с багагүй, шилжисхийлтэнд 4.9-5.9 МПа (50-60 кгх/см<sup>2</sup>)-с багагүй байна.

### **Г.18. Химийн ислийн болон идэвхигүй бүрээс**

18.1 Нүүрстөрөгчит ганг бүрэх

18.1.1 Хим.Окс бүрээс нь ашиглалтын 1-р нөхцөлд зэврэлтээс хамгаалах, мөн будаг, лак, цавуу гэх мэтийн барьцалдалтыг нэмэгдүүлэхэд ашиглагддаг.

18.1.2 Ийм бүрээс нь ихээхэн сүвэрхэг, хамгаалах чанар багатай бөгөөд саармаг тос шингээхэд сайжирдаг.

Элэгдэлд амархан өртөнө, гагнах, ширээх боломжгүй.

18.2 Хөнгөн цагаан ба хөнгөн цагааны хайлшийг бүрэх

18.2.1 Хим.Окс бүрээс нь хамгаалах болон механик бат бэх чанар багатай, үндсэн металлтай сайн барьцалддаг, цахилгаан дамжуулдаггүй, 80°C хүртлэх температурт тэсвэртэй.

18.2.2 Хим.Окс.э бүрээс нь цахилгаан дамжуулах чадвартай, хамгаалах болон механик бат бэх чанар багатай, 80°C хүртлэх температурт тэсвэртэй, долгион дамжуулгын зам дотор өндөр давтамжтай энергийн замхралтанд нөлөөгүй.

18.3 Зэс, зэсийн хайлш, болон өндөр чанаржуулсан ганг бүрэх

18.3.1 Хим.Пас бүрээс нь зэс, зэсийн хайлшийн гадаргууг богино хугацаанд исэлдэх, харлахаас хамгаалдаг. Өндөр чанаржуулсан гангийн зэврэлт тэсвэрлэх чанарыг бага зэрэг нэмэгдүүлдэг.

18.3.2 Эдлэхүүний зэврэлтэнд тэсвэртэй чанарыг нэмэгдүүлэхийн тулд тосолгооны материал эсвэл будаг, лак хэрэглэх шаардлагатай.

18.3.3 Ийм бүрээс нь контактын зэврэлтээс хамгаалахад тохиромжгүй.

18.3.4 Бүрээс нь үндсэн металлын соронзон эсэргүүцэх чанарт нөлөөлөхгүй.

18.4 Магнийн хайлшийг бүрэх

18.4.1 Ийм бүрээс нь зөвхөн үйлдэл хоорондын хадгалалт ба завод доторх тээвэрлэлтийн үед зэврэлтээс хамгаална. Будаг, лакны барьцалдалтыг бага зэрэг нэмэгдүүлдэг.

18.4.2 Ийм бүрээс нь элэгдэлд тэсвэр багатай, механик үйлчлэлээр амархан эвдэрдэг. 150°C хүртлэх температурт тэсвэртэй, хайлшийн цуцалтын бат бэх чанарт нөлөөлөхгүй.

18.4.3 5-6 хүлцэлийн багцтай (нарийвчлалын 1-2 анги) эдлэхүүнийг бүрэхэд уусмал ашигладаг бөгөөд бүрэлтийн үр дүнд эдлэхүүний хэмжээ өөрчлөгддөггүй.

18.4.4 Угсрагдах эдлэхүүнүүдийн бүрээсийг зөвхөн шүргэлцэх металлуудад зэврэлт үүсгэдэггүй уусмалд бүрэхийг зөвшөөрнө.

### **Г.19. Химийн фосфатан бүрээс**

19.1 Бүрээс ган эд ангиудыг зэврэлтээс хамгаалах, лакан будган материалуудын, цавууны барьцалдалтыг нэмэгдүүлэх зориулалтаар, мөн түүнчлэн цахилгаан тусгаарлагч бүрээс болж хэрэглэгдэнэ.

Хроматын уусмалд боловсруулснаар хамгаалах чанар нь сайжирдаг.

19.2 Бүрээс 500°C хүртэлх температурт цахилгаан тусгаарлах өндөр чадварыг агуулж байдаг; нэвтлэх хүчдэл - 300-1000 В;

механик бат бэх багатай, амархан элэгддэг;

хэврэг, цохилтын хүчинд тэсвэргүй, үндсэн металлын 180° -н гулзайлтын үед ан цав үүсэх ба гулзайлтын шугамын дагуу хагарах боловч ховхрохгүй.

хайлсан металл түрхэгдэхгүй;

гагнах болон ширээх боломжгүй

Бүрээс нь гангийн соронзон шинж чанар болон бат бэх, хатуулагт нөлөөлөхгүй.

19.3 Хүхэрт устөрөгчөөс бусад төрөл бүрийн хий, уусгагч, бензол, халуун тосны үйлчлэлд өндөр тэсвэртэй.

19.4 Бүрээсний гадаргуугийн нягт нь 0.001-0.01 кг/м<sup>2</sup> байна.